



Улсын Дээд Шүүхээс картель болон гэрээний чөлөөт байдлын зарчмыг тайлбарласан нь

2024 оны 9-р сар

Бэлтгэсэн: Р. Мөнхжаргал – хуульч, өмгөөлөгч
Э. Аззаяа – хуульч, өмгөөлөгч

Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн гол зорилго нь шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах, өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийг хориглох, хязгаарлах явдал байдаг. Шударга бус өрсөлдөөн нь олон арга хэлбэрээр илрэх боломжтой ба үүний нэг нь өрсөлдөөнд харш гэрээ, хэлцэл (картель) юм. Ийм ч учраас шударга өрсөлдөөний эрх зүйн зохицуулалт нь ийм төрлийн гэрээ, хэлцлийг хориглож хязгаарладаг.

Монгол Улсын Дээд Шүүхээс өрсөлдөөнд харш гэрээ, хэлцэл (картель)-ийг Иргэний эрх зүйн гэрээний чөлөөт байдлын зарчимтай хэрхэн уялдах, гэрээг өрсөлдөөнийг хязгаарлах үндсэн зорилгоор байгуулаагүй мөн гэрээ хэрэгжсэн эсэхээс үл хамааран хэлбэрийн шаардлага хангагдсан тохиолдолд аливаа гэрээг өрсөлдөөнийг хязгаарласанд тооцох талаар энэхүү шийдвэрийг 2020 онд гаргажээ. Иймд Монгол Улсын Дээд Шүүхээс хэрхэн тайлбарласныг хураангуйлан дор толилуулав.

Юу болов?

А ХК болон М ХХК (хамтран нэхэмжлэгч) нар хамтран ажиллах гэрээ байгуулахдаа Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ байгуулж зах зээлийн нутаг дэвсгэр, бараа бүтээгдэхүүний үнийг хэлцэн тогтоосон гэсэн үндэслэлээр А ХК-ийг 113.196.980 төгрөгөөр, М ХХК-г 13,265,110 төгрөгөөр тус тус торгох шийтгэлийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (“ШӨХТГ”)-аас оногдуулсан.

Тус хамтран ажиллах гэрээний дараах заалтууд нь өрсөлдөөнийг хязгаарласанд тооцоогдоно гэж үзэж ШӨХТГ-аас шийтгэл оногдуулсан байна. Үүнд:

- Гэрээний 2.2.2-т “талууд жижиглэн борлуулалтад нэг үнийн бодлого баримталж ажиллана”;
- Гэрээний 3.3-т “Жижиглэн борлуулалтын үнийг 14000 төгрөг /НӨАТ/-гүй” болгон ижил хэмжээгээр тогтоосон буюу тогтсон нэг үнээр борлуулахаар харилцан тохиролцсон;
- Гэрээний 1.6-т заасны дагуу нийлүүлэх нүүрсний зах зээлийг 60:40 (М ХХК 60 хувь, А ХК 40 хувь) харьцаагаар тус тус хуваан нийлүүлэхээр тохиролцсон.

Хамтран нэхэмжлэгч нь хамтран ажиллах гэрээг Иргэний хуульд заасан шаардлагын хүрээнд байгуулсан ба өрсөлдөөнийг хязгаарлахад чиглээгүй, зориогүй гэж маргасан бөгөөд дараах үндэслэлээр өрсөлдөөнийг хязгаарласан шинжийг хамтран ажиллах гэрээ агуулаагүй гэж маргасан байна. Үүнд:

- Гэрээнд заасан үнэ нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны 12 дугаар сарын 233 дугаар тогтоолоор тодорхойлогдсон хэмжээтэй нийцдэг. Худалдах, худалдан авах гэрээ байгуулж байгаа учраас барааныхаа үнийг гэрээндээ тусгах нь хууль зөрчсөн асуудал биш, гэрээ байгуулах наад захын шаардлага юм. Харин ч барааныхаа үнийг тодорхой заагаагүй тохиолдолд гэрээ байгуулагдаагүй гэж Иргэний хуулиар үздэг.



- Хамтран ажиллах гэрээ нь Иргэний хуульд заагдсан ажил гүйцэтгэх, худалдах, худалдан авах гэрээний зохицуулалт /"М" ХХК өөрийн тусгай зөвшөөрлийн талбайгаас "А" ХК-аар олборлолт хийлгэх, олборлосон нүүрсийг "А" ХК-д худалдаж байгаа/-ыг хамруулсан. Гэрээнд 60:40 гэсэн харьцааг гаргасан нь тухайн үед нийт борлуулах нүүрсний хэмжээг урьдчилан мэдэх боломжгүй /гэрээндээ заах боломжгүй/ байсан тул Талууд тус харьцаагаар нүүрс худалдана, худалдан авна гэдэг тохиролцоогоо л баталгаажуулсан хэлбэр юм.

Улсын дээд шүүхийн шийдвэр

Хяналтын шатны шүүх хэргийг хянаад дараах дүгнэлтийг гаргасан байна. Үүнд:

Өрсөлдөөнийг хязгаарлах зорилгын тухайд: Тухайн гэрээ, хэлцлийн үнийг тогтооход өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн зорилготой байсан эсхүл шууд тийм зорилгогүй боловч тухайн хэлцлийн үр дүнд өрсөлдөөн хязгаарлагдах үр дагавар гарахаар бол бараа бүтээгдэхүүний үнийг урьдчилан хэлцэн тохирсонд тооцогдох бөгөөд энэ нь "шударга бус" хэмээх нөхцөлд хамаарч хориглогдсон гэж үзэхээр байна.

Гэрээний чөлөөт байдлын хязгаар: Хэдийгээр аж ахуй эрхлэгчид нь хоорондоо Иргэний хуульд заасан гэрээ хэлцэл байгуулах эрхтэй ч уг хэлцлийн агуулга нь хуулиар хамгаалагдсан нийтийн ашиг сонирхлыг хөндсөн байж болохгүй, тодруулбал, өрсөлдөөний эрх зүйгээр хамгаалагдсан нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн гэрээ хэлцэл байгуулах эрхгүй, энэ тохиолдолд тухайн харилцаа нь хувийн эрх зүйн бус, харин нийтийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд хамаарах бөгөөд дээрх гэрээгээр өрсөлдөөний үр дүнд бараа бүтээгдэхүүний хямд үнэ тогтох чөлөөт зах зээлийн нөхцөлийг үгүйсгэх байдлаар үнэ тохиролцсон, үүнийг хууль тогтоогчоос "шударга бус өрсөлдөөн" гэж хуулиар тусгайлан авч үзсэн тул "...Иргэний хуулийн хүрээнд хамаарах гэрээ...", "...өрсөлдөөнийг хязгаарлах зорилгогүй..." гэх агуулгаар гаргасан хяналтын гомдлыг хүлээн авах боломжгүй.

Зах зээлийг хуваарилсан тухайд: Зөрчлийн тухай хуулийн 10.7 дугаар зүйлийн 1.3-т "... гэрээ, хэлцэл (картель) байгуулсан..." гэж зааснаас үзэхэд тухайн зөрчил нь "хэлбэр"-ийн бүрэлдэхүүнтэй буюу заавал материаллаг хохирол учирсан, эсхүл таамагласнаас өөр үр дүнд хүрсэн эсэхийг шаардахгүй, гэрээ, хэлцэл (картель) байгуулагдсанаар төгссөнд тооцогдох зөрчил учир "...нүүрсний зах зээлийг 60:40 харьцаагаар тус тус хуваан нийлүүлэхээр заасан нь "хэрхэн биелсэн" талаар хариуцагчаас нотолсон ямар ч бичгийн нотлох баримт байхгүй" гэх гомдол няцаагдаж байна.

Ямар ач холбогдолтой вэ?

Хяналтын шатны шүүхээс өрсөлдөөнд харш гэрээ, хэлцэл (картель)-ийг Иргэний эрх зүйн гэрээний чөлөөт байдлын зарчимтай хэрхэн уялдах, гэрээг өрсөлдөөнийг хязгаарлах зорилгоор байгуулаагүй мөн өрсөлдөөнийг хязгаарласан гэрээний зүйл заалт биелээгүй тохиолдолд энэ нь шударга бус өрсөлдөөнд тооцох эсэх асуудлыг тайлбарлан шийдвэрлэжээ. Товчхондоо:

- Гэрээний талууд чөлөөт байдлын зарчмыг үндэслэн аливаа гэрээ, хэлцлийг байгуулах хэдий ч өрсөлдөөний эрх зүйгээр хамгаалагдсан нийтийн ашиг сонирхлыг хөндөж, өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлсэн бол шударга бус өрсөлдөөнд тооцно.
- Гэрээг байгуулахдаа талууд өрсөлдөөнийг хязгаарлах шууд болон шууд бус зорилго тээгээгүй ч тухайн гэрээ, хэлцлийн үр дүнд өрсөлдөөн хязгаарлагдах нөхцөл байдал үүсэж байвал шударга бус өрсөлдөөнд тооцно.
- Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл нь "хэлбэр"-ийн бүрэлдэхүүнтэй зөрчил учир тухайн гэрээ, хэлцэл болон гэрээний заалт нь биелсэн эсэхээс үл хамаарч шударга бус өрсөлдөөнд тооцно.

Компаниудын анхаарах асуудал

Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл (картель)-тэй холбоотой Монгол Улсын Дээд Шүүхийн шийдвэр нь шударга бус өрсөлдөөнийг тогтоох эрх зүйн орчин, шалгуурыг тодорхой болгож байгаагаараа Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдэд ихээхэн ач холбогдолтой. Улмаар аж ахуй нэгжүүд аливаа гэрээ хэлцлийг байгуулахдаа тухайн гэрээ, хэлцэлд үнэ урьдчилан тогтоох, зах зээл хуваарилах, үйлдвэрлэл борлуулалтыг хязгаарлах, тендерт хуйвалдан оролцох гэх зэрэг өрсөлдөөнийг хязгаарлах, өрсөлдөөнд харш аливаа зүйл заалт орсон эсэхийг нягталж шалгах шаардлагатай. Иймд, бизнес эрхлэгчид шударга бус өрсөлдөөнд оролцох, буруутгагдах учирч болзошгүй эрсдэлүүд болон хүлээх хариуцлагыг ойлгож, өрсөлдөөний хууль тогтоомжийг дагаж мөрдөх талаар мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй.

Та шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь уншихыг хүсвэл [Энд](#) дарна уу.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл бидэнтэй холбогдоорой!

Өрсөлдөөнийг хязгаарласанд тооцох, өрсөлдөөнд харш үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө авах цаашлаад өрсөлдөөний хууль тогтоомжийн нийцлийн талаар дэлгэрэнгүй ярилцах хүсэлтэй бол бидэнтэй холбогдоно уу.

Серги Кобахидзе

Евроази хариуцсан Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
sergi.kobakhidze@pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Ахлах менежер
Хуулийн зөвлөх үйлчилгээ
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Энхжаргалын Аззаяа

Ахлах хуульч
Хуулийн зөвлөх үйлчилгээ
azzaya.enkhjargal@pwc.com

Өмгөөллийн ПрайсотэрхаусКүүпэрс Легал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089

www.pwc.com/mn

Манай бусад үйлчилгээтэй [Энд дарж](#) танилцана уу.



PwC Legal
A multidisciplinary law firm

www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирох тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгад үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

© 2024 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү баримт бичигт дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ.